



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 11 сарын 24 өдөр

Дугаар 221

Улаанбаатар хот

Хаалттай хүрээнд санал болгон гаргаж
буй үнэт цаасыг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 5.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Даваанбулаг” ХК-ийн өрийг хувьцаагаар солих зорилгоор хаалттай хүрээнд санал болгон гаргаж буй 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1,788,500 /нэг сая долоон зуун наян найман мянга таван зуу/ ширхэг энгийн хувьцааг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Лхагвасүрэн/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд бүртгэхийг “ҮЦТХТ” ХХК /Ш.Лхагва/-д тус тус үүрэг болгосугай.

2. Компанийн өрийг хувьцаагаар солих зорилгоор нэмж гаргасан энгийн хувьцааг хувьцаа эзэмшигч тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхтэй болохыг дурдсугай.

3. Нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулсантай холбогдуулан үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль тогтоомж, Хорооноос баталсан дүрэм, журмыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг дээдлэн ажиллахыг “Даваанбулаг” ХК /Ж.Мөнхбаяр/-д үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд болон Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт ажлын 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН